

Гэрээний дугаар _____ Үйлчилгээний салбар: _____ Ажилтны нэр: _____

ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Өргөдлийн маягтын төрөл: Шинэ хэрэглэгч Эзэмших эрх шилжих Гэрээ шинэчлэх Багц өөрчлөлт

Ургийн овог: _____ Эцэг/эхийн нэр: _____ Нэр: _____

Регистрийн дугаар: _____ Хүйс: Эрэгтэй Эмэгтэй

Албан ёсны хаяг: Хот/аймаг _____ Дүүрэг/сум _____ Хороо/баг _____

Хороолол/гудамж _____ Байр _____ Тоот _____

Гар утас: _____ Утасны дугаар: _____ И-мэйл: _____

/Төлбөрийн мэдээлэл, идэвхжүүлэх нод авах дугаар/

ХЭРЭГЛЭГЧИЙН НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Үйлчилгээ авах хаяг: Өөрийн эзэмшил Түрээс

Хот/аймаг _____ Дүүрэг/сум _____ Хороо/баг _____

Хороолол/гудамж _____ Байр _____ Тоот _____

ЯАРЛАТ ҮЕД ХОЛБОО БАРИХ ИТГЭМЖЛЭГДСЭН ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ

Овог/Нэр: _____ Утас: _____ Таны хэн болох: _____

Овог/Нэр: _____ Утас: _____ Таны хэн болох: _____

ШИНЭЭР АВЧ БУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Холболтын хураамж _____ ₮ Cally дугаар: _____

Сонгосон багц: X20 X60 X100 Бусад * Сарын суурь хураамж _____ ₮

G150 G300 G600 * Сарын суурь хураамжид өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс ороогүй болно.
* Сарын суурь хураамж нь таны видео сангийн хэрэглээ болон нэмэлт үйлчилгээ идэвхжүүлэлт, цуцлалтаас шалтгаалан хувьсахыг анхаарна уу!

НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

SkyGO ТВ САЛААЛАЛТ Салаа төхөөрөмжийн тоо _____ Салаа төхөөрөмжийн үнэ _____ НЭМЭЛТ ИНТЕРНЭТ...../mbps/

ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨЛБӨР

УРАМШУУЛЛЫН НӨХЦӨЛӨӨР ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛӨӨР

Үндсэн үйлчилгээ төхөөрөмж	Үндсэн үнэ	Урамшууллын үнэ	Гэрээний хугацаа
Гуравласан үйлчилгээ	HD бокс Wi-Fi цацагч	-----	36 сар
	Wi-Fi цацагч	-----	36 сар
	ONT	-----	36 сар

Үндсэн үйлчилгээ төхөөрөмж	Үндсэн үнэ	Урьдчилгаа төлбөр	Лизингийн сарын төлбөр	Лизингийн хугацаа
Гуравласан үйлчилгээ	HD бокс Wi-Fi цацагч	-----	-----	36 сар
Дан интернэт	Wi-Fi Цацагч	-----	-----	-----
Телевиз салаалалт	HD бокс	-----	-----	12 сар

Төхөөрөмжийн урьдчилгаа төлбөр, лизингийн төлбөр, холболтын хураамж нь эхний сарын суурь хураамж дээр нэмэгдэж нэхэмжлэгдэх ба та төлбөрөө үйлчилгээний салбар, онлайн банк болон дансаар төлөх боломжтой.

ХЭРЭГЛЭГЧИЙН АШИГЛАХ КОД

Wi-Fi НЭР _____ Суурин утасны пин код***: _____

Wi-Fi нууц үг * _____ Админ нууц үг*: _____

Суурин утасны дугаар _____ Видео сангийн нууц үг **: _____

Дээрх бүх үнэд НӨАТ орсон болно

*Админ нууц үг нь Skytel.mn-д нэвтрэхэд ашиглагдана.

**Видео сангийн нууц үг нь видео сангаас кино үзэх, menu цэсний тохиргоо хэсэгт тохиргоо хийхэд ашиглана.

***Хэрэглэгч гэрээний 5.3 дахь заалтыг мөрдлөг болгон Cally утасныхаа ПИН кодыг нууцлах шаардлагатай.

Миний бие Скаймедиа корпораци ХХК-ийн төхөөрөмж лизингээр худалдах, худалдан авах гэрээний нөхцөлтэй бүрэн танилцаж зөвшөөрөн, хувийн мэдээллээ үнэн зөв мэдүүлсэн бөгөөд өөрийн талаарх мэдээлэл болон зээлийн мэдээллийг цуглуулах, ашиглах, эрх бүхий байгуулагатай солилцох эрхийг үйлчилгээ үзүүлэх талд олгосноо баталгаажуулж гарын үсэг зурсан болно.

ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН ҮСЭГ

Хэрэглэгч би өөрийн хаягийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн Ерөнхий хуулийн 15.5.1-д заасны дагуу гаргуулан авах эрхийг SKAYmedia корпораци ХХК-д үүгээр мөн зөвшөөрөн.

ОГНОО: 20 ____ ОНЫ ____ САРЫН ____ ӨДӨР



ГУРАВЛАСАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Энэхүү СКАЙМЕДИА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ /цаашид "Гэрээ" гэх/-г Нэг талаас: 9019020032 тоот Улсын бүртгэлийн дугаартай, 2619032 тоот регистрийн дугаартай Монгол Улсын хуулийн этгээд болох СКАЙМЕДИА КОРПОРАЦИ ХХК /цаашид "Үйлчилгээ үзүүлэгч" гэх/, Нөгөө талаас: Монгол Улсын Иргэн овогтой /цаашид "Хэрэглэгч" гэх/ нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ дараах харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Гэрээний зорилго нь Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн шилэн кабелийн хамрах хүрээнд Хэрэглэгчид Ай Пи телевиз, Сүүрэн интернет, Cally IP утас бүхий гуравласан үйлчилгээг, эсхүл дангаар буюу аль нэг үйлчилгээг, бусад захиалгат үйлчилгээ /Цаашид "Үйлчилгээ" гэх/-г үзүүлэх, Хэрэглэгч нь энэхүү гэрээнд заасны дагуу үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн шилэн кабелийн хамрах хүрээнд телевиз үзэх, бусад үндсэн болон захиалгат үйлчилгээгээр үйлчлүүлэх бололцоогоор хангагдана.
- 1.3. Cally үйлчилгээний дугаар нь Үйлчилгээ үзүүлэгчийн өмчлөлд байх бөгөөд гэрээний хүчин төгөлдөр хугацаанд тэдгээрийн зөвхөн эзэмшис эрхийг Хэрэглэгчид олгоно.
- 1.4. Энэхүү гэрээний хавсралтад Хэрэглэгчийн мэдээлэл, үйлчилгээний нөхцөл, тоног төхөөрөмжийн мэдээлэл болон мэдээллийн зэний зөвшөөрлийн хуудсыг Гэрээтэй хамт хэрэглэх ба эдгээр нь Гэрээний салшгүй хэсэг байна. Хэрэв дээрх баримт бичиг хоорондоо зөрчилдвөл Гэрээг удирдлага болгоно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээ нь Хэрэглэгч Скаймедиа үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж гэрээ цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГУРАВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Хэрэглэгч нь дараах эрхтэй

- 3.1.1 Хэрэглэгч нь эрх бүхий байгууллагаас баталсан стандарт техникийн нөхцөл, түнчлэн Монгол Улсын хууль тогтоомж, энэ гэрээгээр тодорхойлсон зохих чанар, тоо хэмжээ, аюулгүйн шаардлагыг хангасан үйлчилгээгээр хангуулах эрхтэй.
- 3.1.2 Үйлчилгээ үзүүлэгчээс тогтоосон техникийн нөхцөл, шаардлагыг хангаж баталгаажсан тоног төхөөрөмж ашиглах эрхтэй.
- 3.1.3 Хэрэглэгч Скаймедиа үйлчилгээний нөхцөлд заасны дагуу Захиалгат үйлчилгээг авах эрхтэй.
- 3.1.4 Хэрэглэгч үйлчилгээний гэрээ байгуулахад өөрийн биеэр цахим үнэмлэхний хамт ирнэ. Хэрэглэгч өөрийн биеэр ирэх боломжгүй бол нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг үндэслэн зөвхөн итгэмжлэлд заасан үйлчилгээг итгэмжлэгдсэн төлөөлөгчид үзүүлэх эрхтэй.
- 3.1.5 Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчээс олгож буй үйлчилгээ, хөнгөлөлт, урамшуулал, үнэ тарифын талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомж, Үйлчилгээ үзүүлэгчийн дүрэм, журам, үйлчилгээний нөхцөлийн хүрээнд авах эрхтэй.
- 3.1.6 Үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох баримт бичгийн дугаар, лиценз олгосон байгууллагын талаарх мэдээллийг шаардан үзэх эрхтэй.
- 3.1.7 Үйлчилгээний талаар санал, гомдол гаргах, талархал илэрхийлэх эрхтэй.

3.2 Хэрэглэгч нь дараах үүрэгтэй

- 3.2.1 Хэрэглэгч нь өргөдлийн маягтыг үнэн зөв бөглөх үүрэгтэй.
- 3.2.2 Хэрэглэгч нь өргөдлийн маягтын мэдээлэлд өөрчлөлт орвол ажлын 5 хоногт багтаан Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй.
- 3.2.3 Үйлчилгээ үзүүлэгчээс олгож байгаа үйлчилгээг энэхүү Гэрээ болон Скаймедиа үйлчилгээний нөхцөлд заасан нөхцөлөөр ашиглах үүрэгтэй.
- 3.2.4 Өмнөх сард ашигласан үйлчилгээний төлбөрөө Скаймедиа үйлчилгээний нөхцөлийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дэх заалтад заасан хугацаанд бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.2.5 Хэрэглэгч интернет орчны хүрээг тэлэх зорилгоор нэмэлт төхөөрөмж байршуулах тохиолдолд төхөөрөмжийн нэмэлт үнийг төлөх үүрэгтэй.
- 3.2.6 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрийг төлөхөөс өмнө тооцооны үнэн зөвийг нягтлан шалгах үүрэгтэй. Энэ үүрэг биелүүлэггүй тохиолдолд тухайн төлбөртэй холбоотой аливаа гомдлыг Үйлчилгээ үзүүлэгч хүлээж авахгүй.
- 3.2.7 Хэрэглэгч Захиалгат үйлчилгээ авах тохиолдолд Скаймедиа үйлчилгээний нөхцөлд тухайлан заасан шаардлагыг хангасан байх үүрэгтэй.
- 3.2.8 Хэрэглэгч үйлчилгээг гуравдагч этгээдэд дамлан борлуулах, хууль бусаар ашиглахгүй байх үүрэгтэй.
- 3.2.9 Хэрэглэгч нь үйлчилгээг зүй зохистой бусаар /бусад хэрэглэгчийг залхаах, дарамтлах, гутаан доромжлох, өөр бусад байдлаар бусдын амгалан байдлыг алдагдуулах, сүлжээний хэвийн үйл ажиллагааг саатуулах, хүндрэл учруулах зэргээр/ ашиглахгүй байх үүрэгтэй.
- 3.2.10 Хэрэглэгч Үйлчилгээ үзүүлэгчээс олгосон нууц код /Sip код/, Wi-Fi код, үйлчилгээтэй холбоотой бусад нууц үг, нууц дугаарыг бусдад мэдэгдэж болохгүй. Хэрэв бусдад мэдэгдсэн, мэдэгдсэн байж болзошгүй бол Үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй хандаж нууц үг, нууц дугаарыг солих, үйлчилгээг хаалгах хүртэл арга хэмжээг авахуулах үүрэгтэй.
- 3.2.11 Хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлэггүйгээс шалтгаалан үйлчилгээний төлбөр өндөр гарах, үйлчилгээ доголдох, тасалдах гэх мэт аливаа асуудал, эрсдэл үүссэн тохиолдолд Хэрэглэгч өөрөө бие даан хариуцах ба Үйлчилгээ үзүүлэгч ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
- 3.2.12 Хэрэглэгч нь үндсэн багцын суурь хураамжийн төлбөрийг төлөх үүрэгтэй.
- 3.2.13 Хэрэглэгч үйлчилгээг 36 сарын турш тасралтгүй ашиглах үүрэгтэй.

ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрхтэй

- 4.1.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн үйлчилгээний төлбөрийг Скаймедиа үйлчилгээний нөхцөлд зааснаар тооцож, мөн нөхцөлд тухайлан заасан өдөр нэхэмжлэх эрхтэй.
- 4.1.2 Үйлчилгээ үзүүлэгч нь Cally үйлчилгээний дугаарын өмчлөгч бөгөөд гэрээ цуцлагдаж, дуусгавар болсон тохиолдолд тухайн дугаарыг буцаан авах эрхтэй.
- 4.1.3 Үндсэн багцын үйлчилгээний үнэ тарифыг тогтоох эрхтэй.
- 4.1.4 Ай Пи телевизийн сувгийн дараалал, гадаад дотоод сувгуудад нэмэлт, өөрчлөлт оруулах /суваг нэмэх, хасах/ эрхтэй.
- 4.1.5 Үйлчилгээ үзүүлэгч нь зах зээлийн нөхцөл байдал, төрийн байгууллагын шийдвэр болон хэрэглэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах шаардлагын улмаас

Скаймедиа үйлчилгээний нөхцөл, үнэ тариф болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй ба энэ тохиолдолд Хэрэглэгчид ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мессежээр эсхүл үйлчилгээний салбар болон Skytel.mn веб хуудсын аль нэгээр мэдэгдэх ба шаардлагатай тохиолдолд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэнэ.

- 4.1.6 Хэрэглэгч нь ийнхүү мэдэгдсэнээс хойш өөрчлөгдсөн нөхцөлийг хүлээн зөвшөөрөх эсэх талаар ажлын 10 хоногийн дотор мэдэгдээгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн саналыг буюу нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох ба Скаймедиа үйлчилгээний нөхцөл, үнэ тарифын өөрчлөлттэй танилцаагүй, мэдээгүй нь төлбөр төлөх үүрэг болон бусад үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
 - 4.1.7 Хэрэглэгч үйлчилгээний нөхцөлд зааснаар үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд төлбөр төлөх хүртэлх хугацаанд үйлчилгээнд хязгаарлалт хийх эрхтэй.
 - 4.1.8 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үндэслэлээр Хэрэглэгчид урьдчилан сануулалгүйгээр үйлчилгээний эрхийг хаах эрхтэй. Үүнд:
 - 4.1.8.1 Өргөдлийн маягтын мэдээллийг санаатайгаар худал мэдүүлсэн, эсхүл 3.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол;
 - 4.1.8.2 Хэрэглэгч гэрээний хаяг дээрээ оршин суудаггүй болох нь тогтоогдсон бол;
 - 4.1.8.3 Үйлчилгээ үзүүлэгчийн бусад үйлчилгээнд төлбөрийг маргаантай бол;
 - 4.1.8.4 Үйлчилгээг зүй зохистой бусаар ашигласан тохиолдолд;
 - 4.1.9 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд өр авлага барагдуулах зорилгоор Зээлийн мэдээллийн тухай хууль болон Төв банк /Монголбанк/-тай байгуулсан гэрээний дагуу зээлийн мэдээллийн санд зээлийн ангиллыг бүртгүүлэх, мөн түүнчлэн хууль тогтоомжид заасны дагуу бусад арга хэмжээг авах эрхтэй.
 - 4.1.10 Хэрэглэгч дахин шинэ үйлчилгээ авах хүсэлт гаргасан тохиолдолд өмнө байгуулсан гэрээтэй холбоотой ямар нэгэн төлбөр тооцоотой асуудал үүссэн бол дахин гэрээ байгуулахаас татгалзах эрхтэй.
- #### 4.2 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүрэгтэй
- 4.2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийг Скаймедиа үйлчилгээний нөхцөлд заасан өдөр и-мэйл хаяг, хэрэглэгчийн бүртгэлтэй утасны дугаар, цахим салбар /IPTV/-ын аль нэгээр хэрэглэгчид мэдэгдэх үүрэгтэй.
 - 4.2.2 Үйлчилгээ үзүүлэгч нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5.3-т заасны дагуу хэрэглэгчийн төлбөрөөс өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлд тооцож, Монголын телевизүүдийн холбоонд шилжүүлэх үүрэгтэй.
 - 4.2.3 Аливаа гэмтэл, саатлыг шийдвэрлэхэд тухайн гэмтэл саатлын төрөл, засварлах хугацаа зэргээс хамаарч 48 цаг болон түүнээс доош, боломжит хугацаанд хурдан шуурхай гүйцэтгэж хэвийн ажиллагаанд оруулах үүрэгтэй.
 - 4.2.4 Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчид үйлчилгээг өөрийн техникийн боломж болон хүчин чадлын хүрээнд чанарын өндөр түвшинд үзүүлнэ. Үйлчилгээ үзүүлэгчийн Хэрэглэгчид хүргэж буй үйлчилгээнд ачаалал ихтэй үеэр доголдол, саатал гарч болох бөгөөд энэ тухай Хэрэглэгчид урьдчилан сануулах үүрэгтэй.
 - 4.2.5 Үйлчилгээ үзүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан үйлчилгээ тасалдсан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох инженерийн дүгнэлтийг үндэслэн тасалдсан хугацааны төлбөрийг Хэрэглэгчийн тухайн сарын үйлчилгээний төлбөрөөс хасаж тооцох эсхүл хөнгөлөлт, урамшууллыг олгох үүрэгтэй.
 - 4.2.6 Үйлчилгээтэй холбоотой хэрэглээний дэлгэрэнгүй мэдээллийг Хэрэглэгч авахыг хүсвэл цаг тухайд нь гаргаж өгөх үүрэгтэй.
 - 4.2.7 Хэрэглэгчийн мэдээллийн нууцыг чанд хадгалах үүрэгтэй.

ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 5.1 Хэрэглэгч нь үйлчилгээг түр салгах хүсэлтээ өгөх хүртэлх үйлчилгээний төлбөр тооцоогоо өөрөө бүрэн хариуцна.
- 5.2 Хэрэглэгч нь үйлчилгээний эрхээ Үйлчилгээ үзүүлэгчид албан ёсоор хандан гэрээний үндсэн дээр шилжүүлэхээс бусад байдлаар дур мэдэн гуравдагч этгээдэд шилжүүлсэн бол түүнээс үүдэн гарах хохирлыг бие даан бүрэн хариуцна.
- 5.3 Хэрэглэгч Cally үйлчилгээний дугаараа гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүй байдлаар дамжуулсан, ашиглуулсан, аль нэг программыг буруу ажиллуулсан, эсхүл энэхүү гэрээний 3.2.8-д заасан үүргээ зөрчсөнөөс үүсэн гарсан аливаа үр дагавар, хохирол, зардлыг Хэрэглэгч бүрэн хариуцна.
- 5.4 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, төлбөрийн үлдэгдэлтэй бөгөөд өргөдлийн маягтад заасан хаягтаа байхгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн үйлчилгээний төлбөр төлөх үүргийн талаар болон өр авлага барагдуулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, төлбөр төлөхийг шаардах эрхийг гуравдагч этгээдэд өгөхийг Хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр шийдвэрлэнэ.
- 5.5 Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний өргөдлийн маягтад өгөгдсөн Хэрэглэгчийн мэдээлэл болон үйлчилгээний гэрээ, хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг өөрийн нууцад хамааруулан хадгалах бөгөөд дараах тохиолдлуудад гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхтэй. Үүнд:
 - 5.5.1 Хэрэглэгч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн авлагыг барагдуулах зорилгоор;
 - 5.5.2 Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шаардсанаар;
- 5.6 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн нууцад хамаарах мэдээллийг хууль бусаар олж авах аливаа үйлдэл хийсэн, тийнхүү олж авсан мэдээллийг хувийн болон бусад зорилгоор ашигласан, хэрэглэсэн, бусдад зарцуулсан бол энэхүү үйлдлийн улмаас учирсан эсхүл учирч болох аливаа хохирлыг бүрэн хариуцахын зэрэгцээ энэхүү гэрээ болон хуульд заасан бусад хариуцлага хүлээнэ.
- 5.7 "Скаймедиа корпораци" ХХК-тай гэрээ байгуулсан хэрэглэгчийн бүртгэлтэй гар утасны дугаарт холбогдох, мессеж илгээх болон IPTV-цахим салбар, онлайн сувгууд (Скайтел аппликэйшн, веб хуудас, фэйсбүүк мессенжер, цахим хаяг)-аар хэрэглэгчид багц өөрчлөх, гэрээ шинэчлэх үйлчилгээг санал болгож, хэрэглэгч үйлчилгээний нөхцөлийг хүлээн авахгүй тухай харуу мэдэгдлийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд төлбөр, үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөн хэлцэл хийсэнд тооцно.
- 5.8 "Скаймедиа корпораци" ХХК-тай гэрээ байгуулсан хэрэглэгчийн бүртгэлтэй утасны дугаарт илгээгдсэн баталгаажуулах код бүхий мессеж болон онлайн сувгийн бүртгэл зэрэг нь хэлцэл хийснийг нотлох баталгаа болно.

ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО

- 6.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн үйлчилгээний төлбөрийг Скаймедиа үйлчилгээний нөхцөлд зааснаар тооцож мөн нөхцөлд тухайлан заасан өдөр хэрэглэгчээс нэхэмжилнэ.

- 6.2 Хэрэглэгч гэрээг цуцлах хүсэлт гаргасан тохиолдолд цуцалсан сарын төлбөр биллинг циклээр тооцогдож, өмнөх сарын үлдэгдэл төлбөр, төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр, бусад холбогдох төлбөрийг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 6.3 Гэрээний 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу үйлчилгээний төлбөр нэхэмжлээгүй нь Хэрэглэгчийг төлбөр төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.4 Үйлчилгээ үзүүлэгч төлөгдөөгүй төлбөрийг барагдуулахтай холбогдон гарсан нэмэлт зардлыг Хэрэглэгчээс нэхэмжлэх эрхтэй.
- 6.5 Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчээс авсан аливаа үйлчилгээний төлбөрийг хугацаандаа барагдуулаагүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн бусад үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэх дээр нэмж нэхэмжлэх ба үйлчилгээг хязгаарлах эрхтэй.
- 6.6 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0,5% алданги тооцож нэхэмжлэх эрхтэй.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1 Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Талуудын хүсэл зорилгоос үл хамаарах шалтгаанаар тухайлбал гал түймэр, үер, хур тунадас болон шороон шуурга, газар хөдлөлт, аянга цахилгаан, гал уулын болон бусад тэсрэлт, дэлбэрэлт, цаг агаарын хэт халалт ба хүйтрэлт эсхүл төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээрийн дэглэм, гоц халдварт өвчин, ажил хаялт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн, дайн /зарлагдсан

болон зарлагдаагүй/, террорист халдлага, түлш, эрчим хүчний хязгаарлалт сүлжээний хэт ачаалал, доголдол, тасалдал зэрэг гэнэтийн буюу давагдашгүй шинжтэй нөхцөл байдлын улмаас Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийн хариуцлагаас чөлөөлөгдөнө.

- 7.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас үүдсэн нөхцөл байдал 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд Талууд Гэрээг цуцлах талаар саналаа албан ёсоор бичгээр гаргах эрхтэй. Гэрээ цуцалсан тохиолдолд Хэрэглэгч давагдашгүй хүчин зүйл үүсэхээс өмнө авсан үйлчилгээний төлбөрөө барагдуулах үүрэгтэй.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын шүүхээр маргааныг шийдвэрлүүлнэ.
- 8.2 Энэхүү гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна

БАГЦЫН ТӨРӨЛ	X20	X60	X100	G150	G300	G600
Сарын суурь хураамж*	33000₮	44000₮	77000₮	66000₮	99000₮	159000₮
Өргөн нэвтрүүлгийн үндсэн багцын үнэ тариф /23 суваг/	3500₮	2500₮	2500₮	2500₮	2500₮	2500₮
Телевиз салаалалтын сарын суурь хураамж	9900₮	9900₮	9900₮	9900₮	9900₮	9900₮

* Суурь хураамжид Өргөн нэвтрүүлгийн үндсэн багцын үнэ тарифын хөлс ороогүй болно.

*Сарын төлбөр нь видео сангийн хэрэглээ болон нэмэлт үйлчилгээ идэвхжүүлэх, цуцлалтаас шалтгаалан хувьсахыг анхаарна уу!

Гэрээ байгуулсан:

Хэрэглэгч өргөдлийн маягт түүнд агуулагдсан мэдээллийг үнэн зөв өгч, Талууд энэхүү гэрээний нөхцөлд заасан бүхий л заалтууд, мөн тухайлан энэ гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.6 дахь заалтад заасныг болон Скаймедиа үйлчилгээний нөхцөл, түүнд энэ гэрээний дагуу орох аливаа өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж:

Хэрэглэгчийг төлөөлж

Үйлчилгээний салбар

Үйлчилгээний ажилтан

Овог, Нэр

Үйлчилгээний ажилтан



ГУРАВЛАСАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

НЭГ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 1.1. Энэхүү Скаймедиа үйлчилгээний нөхцөлд дараах нэр, томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.1.1 “Хэрэглэгч” гэж үйлчилгээг үзүүлэгчтэй үйлчилгээний гэрээ байгуулж, үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэг хүлээсэн хувь хүнийг;
 - 1.1.2 “Холболтын хураамж” гэж гэрээ байгуулах, үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэхтэй холбоотой үүссэн үйлчилгээний эргэн төлөгдөхгүй нэг удаагийн төлбөрийг;
 - 1.1.3 “Сарын суурь хураамж” гэж сонгосон үйлчилгээний багцаас хамаарч сар бүр тогтмол төлөх төлбөрийг;
 - 1.1.4 “Захиалгат үйлчилгээ” гэж үйлчилгээг түр салгах, нээх, багц шилжүүлэх, телевиз салаалах, хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт авах, хаяг шилжүүлэх үйлчилгээг;
 - 1.1.5 “Төлбөрийн нэхэмжлэх” гэж сарын суурь хураамж, үндсэн багцын суурь хураамж, нэмэлт үйлчилгээний төлбөр, төхөөрөмжийн лизинг бусад холбогдох төлбөр, НӨАТ, нийлбэр дүнг;
 - 1.1.6 “Нэмэлт үйлчилгээ” гэж сонгосон багцад дагалдах хэрэглээнээс бусад нэмэлтээр үзүүлж буй нэмэлт интернэт, нэмэлт салаа тв, нэмэлт сүвгийн багц, нөхөж үзэх, ухраах, зогсоох, дахин эхлүүлэх, бичлэг хийх, видео сангаас контент түрээслэн үзэх гэх мэт;
 - 1.1.7 “Cally үйлчилгээ” гэж интернэт протокол дээр суурилсан харилцаа холбооны үйлчилгээг;
 - 1.1.8 “Олон улсын яриа үйлчилгээ” гэж олон улсын яриа үйлчилгээний барьцаа байршуулсан хэрэглэгч 002 гарцыг ашиглан гадаад улс руу дуудлага хийх, мессеж илгээх үйлчилгээг;
 - 1.1.9 “SkyGo эрх” гэж Скаймедиагийн хэрэглэгч интернэт орчинд гар утас, таблет, компьютер зэрэг төхөөрөмжүүдийг ашиглан суваг болон контент үзэх боломж;
 - 1.1.10 “Биллинг цикл” гэж сарын эхний өдрөөс сүүлийн өдөр дуустал хугацааг;
 - 1.1.11 “Хуруун хээ уншигч” гэж Төрийн мэдээлэл солилцооны ХУР системийн мэдээлэлд үндэслэн хэрэглэгчийн хурууны хээг таньж, улсын бүртгэлийн мэдээллийг хэрэглэгчийн мэдээллийн санд татан авах зориулалт бүхий төхөөрөмжийг;
 - 1.1.12 “Тоног төхөөрөмж” гэж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж буй хэрэгслийг Wi-Fi цацагчтай төхөөрөмж болон HD бокс төхөөрөмжийг;
 - 1.1.13 “Тоног төхөөрөмжийн дагалдах хэрэгсэл” гэж удирдлага, тэжээлийн залгуур, HDMI, AV, LAN кабелүүдийг;
 - 1.1.14 “Тоног төхөөрөмж лизингээр авах” гэж төхөөрөмжийн нийт үнийн дүнгийн тодорхой хувийг урьдчилан төлж, үлдэгдлийг гэрээнд заасан хугацаанд /36 сарын хугацаанд/ хуваан төлж авах;
 - 1.1.15 “Тоног төхөөрөмж урамшууллын нөхцөлөөр авах” гэж 36 сар сарталтгүй ашиглах нөхцөлөөр үнэ төлбөргүй авах;
 - 1.1.16 “Гуравласан үйлчилгээ” гэж Ай Пи Телевиз (IPTV), суурин интернэт үйлчилгээ (Wi-Fi), Cally үйлчилгээг;
 - 1.1.17 “Ай Пи Телевиз (IPTV)” гэж интернэт протокол дээр суурилсан телевизийн үйлчилгээг;
 - 1.1.18 “Суурин интернэтийн үйлчилгээ (Wi-Fi)” гэж интернэт протокол дээр суурилсан дэлхийн компьютерын сүлжээнд холбогдох үйлчилгээг;
 - 1.1.19 “Үндсэн багц” гэж өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.19, 26.5-д заасны дагуу олон нийтийн телевиз, түүний нэмэлт суваг болон өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгуудыг багтаасан үйлчилгээг;
 - 1.1.20 “Үндсэн багцын сарын суурь хураамж” гэж өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26.6, 31.2.2-т заасны дагуу Үйлчилгээ үзүүлэгчийн тогтоосон үйлчилгээний үнэ тарифыг;
 - 1.1.21 “Олон нийтийн телевиз” гэж олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан зөвхөн олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, ашгийн төлөө бус, телевизийн үйлчилгээг;
 - 1.1.22 “Өргөн нэвтрүүлгийн телевиз” гэж олон талт хөтөлбөртэй, олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээгээр заавал дамжих арилжааны телевизийн үйлчилгээг;
 - 1.1.23 “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөл” гэж өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5.3-т заасны дагуу –Үндсэн багцын үйлчилгээний төлбөрөөс тооцож, Монголын телевизүүдийн холбоонд шилжүүлэх төлбөрийг;
 - 1.1.24 “Монголын телевизүүдийн холбоо” гэж өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлсийг төвлөрүүлж, гишүүддээ хуваарилах чиг үүрэг бүхий өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгэдийг;
 - 1.1.25 “Мэдээллийн эзний зөвшөөрлийн хуудас” гэж “Скаймедиа корпораци” ХХК нь Хэрэглэгчид өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхдээ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.4, 8.1, 8.2, 8.3, 8.4, 9.2.1, 18.1, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.4-т тус тус заасны дагуу мэдээллийн эзэнд танилцуулж авсан зөвшөөрлийн нөхцөлийг;

ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 2.1 Шинэ хэрэглэгч болох
 - 2.1.1 Шинэ хэрэглэгчийн гэрээг байгуулахдаа хурууны хээ уншигчийг ашиглана. Шаардлагатай тохиолдолд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 2.1.1.1 Цахим үнэмлэх болон лавлагааны хуулбар (хүчинтэй хугацаа дусаагүй байх);
 - 2.1.1.2 Орон сууцны өмчлөгч болохыг нотолсон бичиг баримт;
 - 2.1.1.3 Хэрэглэгч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч бүс тохиолдолд эд хөрөнгийг эзэмших, ашиглах үндэслэл болох бичиг баримт (гэрээ, хэлцэл)-ийн хуулбарыг;
- 2.2 Холболтын хураамж
 - 2.2.1 Холболтын хураамж нь тухайн сарын үйлчилгээний сарын суурь хураамж дээр нэмж бодогдоно. Холболтын хураамжийн дараах тохиолдолд авна. Үүнд:
 - 2.2.2 Шинэ хэрэглэгч болж байгаа тохиолдолд;
 - 2.2.3 Хэрэглэгчийн гэрийн хаягт өөрчлөлт орж, тоног төхөөрөмж шилжүүлэн суурилуулсан тохиолдолд;
- 2.3 Сарын суурь хураамж
 - 2.3.1 Шинэ хэрэглэгчийн эхний сарын суурь хураамж өдрийн алхмаар тооцогдож бодогдоно.
 - 2.3.2 Сарын дундуур багц хооронд шилжих үед шилжсэн багцын сарын суурь хураамжаар тухайн сарын нэхэмжлэх тооцогдоно.
 - 2.3.3 Сарын суурь хураамж биллинг циклээр буюу ашигласан өдрөөс үл хамааран бүтнээр тооцогдоно.
 - 2.3.4 Үйлчилгээний төлбөрөө хугацаандаа төлөөгүйгээс үйлчилгээ хязгаарлагдсан болон хязгаарлагдсаны улмаас үйлчилгээ нээсэн сарын суурь хураамжийг биллинг циклээр буюу бүтнээр тооцно.
 - 2.3.5 Хэрэглэгч дараах нөхцөлүүдэд сарын суурь хураамжаас чөлөөлөгдөнө. Үүнд:
 - 2.3.5.1 Хэрэглэгч гэрээгээр түр хаалгасан тохиолдолд;
 - 2.3.5.2 Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн эрхийн дагуу хэрэглэгчийн үйлчилгээг бүхэлд нь хаасан тохиолдолд;

ГУРАВ. ЗАХИАЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 3.1 Багц хооронд шилжих
 - 3.1.1 Хэрэглэгч шинэ багцруу шилжин гэрээ шинэчилсэн тохиолдолд тухайн өдрөөс эхлэн гэрээний хугацааг шинээр 36 (гучин зургаа) сараар тооцно.
 - 3.1.2 G багцын хэрэглэгч гэрээний хугацаанд багц ахиж болон бууруулах боломжтой.
 - 3.1.3 X багцын хэрэглэгч гэрээний хугацаанд багц ахиж боломжтой, багц буурах боломжгүй байна. Гэрээний хугацаа дууссан тохиолдолд багц буурах боломжтой.
 - 3.1.4 Багц ахиулах хүсэлт гаргасан өдрөөс багцыг шилжүүлнэ.
 - 3.1.5 Багц буурах хүсэлт гаргасан тохиолдолд сарын 1-ний өдрөөс багцыг шилжүүлнэ.
 - 3.1.6 Сард 1 удаа багц шилжилт хийнэ.
 - 3.1.7 Хэрэглэгч багц ахиулах тохиолдолд лизингээр авсан төхөөрөмжийн урьдчилгаа төлбөр буцаагдахгүй ба лизингийн сарын төлбөр хэвээр үргэлжилнэ.
 - 3.1.8 Гэрээний хугацаа дуусаагүй G багцын хэрэглэгч X багцруу шилжсэн тохиолдолд төхөөрөмжийн төлбөрийг ашигласан хугацаанаас хамаарч тооцож нэхэмжлэнэ.
 - 3.1.9 Хэрэглэгч G багцаас FTTH сүлжээгүй байранд шилжин үйлчилгээг ашиглах тохиолдолд хэрэглэгчийн багцыг X60, X100 багцруу шилжүүлэх боломжтой. /X20 багцруу шилжүүлэх боломжгүй./
- 3.2 Телевиз салаалах
 - 3.2.1 Хэрэглэгч телевиз салаалах үйлчилгээг 3 хүртэлх зурагтад ашиглах боломжтой. Салаалалт бүрийн тоогоор HD бокс төхөөрөмжийг Үйлчилгээ үзүүлэгч тухайн үеийн тогтоосон үнээр урьдчилгаа төлбөр төлж лизингээр авч болно.
 - 3.2.2 Салаа төхөөрөмжийн лизингийн хугацаа 12 сар байна.
 - 3.2.3 Салаа төхөөрөмжийн түр болон бүрэн салгасан эсэхээс үл хамааран ашиглалтыг биллинг циклээр тооцно.
- 3.3 Үйлчилгээ түр салгах, нээх
 - 3.3.1 Хэрэглэгч үйлчилгээг түр хугацаагаар ашиглахгүй тохиолдолд үйлчилгээний салбарт өөрийн биеэр ирж төлбөрийн үлдэгдлийг бүрэн барагдуулснаар түр салгах үйлчилгээг авна.
 - 3.3.2 Үйлчилгээг түр салгах тохиолдолд суурь хураамжийг хоногийн алхмаар тооцно.
 - 3.3.3 Түр салгах үйлчилгээг авсан тохиолдолд энэ хугацааг идэвхтэй ашигласан хугацаанд оруулж тооцохгүй.
 - 3.3.4 Түр салгах үйлчилгээ үнэ төлбөргүй байна.
 - 3.3.5 Түр салгах үйлчилгээний хугацаа биллинг циклээр 12 сар хүртэл байна.
 - 3.3.6 Түр салгах үйлчилгээг сард 1 удаа, жилд 2 удаа авах боломжтой.
 - 3.3.7 Түр салгах үйлчилгээ нь хэрэглэгчийн хүсэлтээр эсхүл 12 сарын хугацаа дууссанаар хаагдаж, хэрэглэгчийн түр салгахаас өмнөх үндсэн болон нэмэлт бүх үйлчилгээ автоматаар нээгдэнэ.
 - 3.3.8 Төлбөрийн үлдэгдэлгүй хэрэглэгч үйлчилгээний салбарт ирэх боломжгүй тохиолдолд бүртгэлтэй гар утасны дугаараас лавлах төвд (1520, 76769000) хандаж түр салгах, нээх үйлчилгээг авч болно.
- 3.4 Нэмэлт үйлчилгээ
 - 3.4.1 Хэрэглэгч нэмэлт үйлчилгээг сарын хэдний өдрөөс үл хамааран мессеж, Скайтел веб сайт, IPTV цахим салбар, үйлчилгээний салбар, лавлах төвд хандан идэвхжүүлэх, цуцлах боломжтой.
 - 3.4.2 Нэмэлт үйлчилгээний төлбөрийг 1 (нэг) сарын алхмаар тооцох бөгөөд сар хүрээгүй хэрэглээг 1 (нэг) бүтэн сараар тооцно.

ДӨРӨВ. ЭЗЭМШИХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

- 4.1 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд эзэмших эрх шилжүүлэгч болон эзэмших эрх хүлээн авагч тус тус өөрийн биеэр үйлчилгээний салбарт хандах ба цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг өгч эзэмших эрх шилжүүлнэ.
- 4.2 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд сар бүрийн 6-ны өдрөөс эхлэн шилжүүлэх бөгөөд нийт төлбөрийн үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна.
- 4.3 Эзэмших эрх шилжүүлсэн тохиолдолд эзэмших эрх хүлээн авсан хэрэглэгчтэй Скаймедиа үйлчилгээний гэрээг шинээр байгуулна.
- 4.4 Дараах хүндэтгэх шалтгаанаар эзэмших эрх шилжүүлэх боломжтой. Үүнд:
 - 4.4.1 Эзэмшигч нас барсан тохиолдолд эрх хүлээн авагч өөрийн биеэр эзэмшигчийн нас барсны гэрчилгээ, эзэмшигчийн гэр бүлийн гишүүн (гэр бүлийн гишүүн гэдгийг эзэмшигчийн эхнэр, нөхөр, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, насанд хурхсан төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүүг ойлгоно) холсыг нотолсон лавлагааны хамт үйлчилгээний салбарт ирнэ.
 - 4.4.2 Эзэмшигч гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа тохиолдолд эрх хүлээн авагч өөрийн биеэр эзэмших эрх шилжүүлэхийг зөвшөөрсөн итгэмжлэлийн хамт үйлчилгээний салбарт ирнэ.

ТАВ. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- 5.1 Тоног төхөөрөмж лизингээр авах
 - 5.1.1 Хэрэглэгчийн төхөөрөмжийн лизингийн хугацаа 36 сар байна.
 - 5.1.2 Хэрэглэгч төхөөрөмжийн урьдчилгаа төлбөрийг төлснөөр лизингээр авах эрх үүсэх ба урьдчилгаа төлбөрийг эхний сарын төлбөр дээр нэхэмжилнэ.
 - 5.1.3 Хэрэглэгч төхөөрөмжийн лизингтэй үед шинэ багц руу шилжсэн тохиолдолд үлдэгдэл лизингийн төлбөр хэвээр байна.
- 5.2 Тоног төхөөрөмж урамшууллын болон лизингийн нөхцөлөөр авах
 - 5.2.1 Хэрэглэгч гэрээний хугацаанд үйлчилгээг сарталтгүй ашиглах нөхцөлөөр төхөөрөмжийг лизинг болон урамшуулалтай нөхцөлөөр авна.
 - 5.2.2 Урамшуулалтай нөхцөлөөр төхөөрөмж авсан хэрэглэгч түр салгах үйлчилгээг авсан тохиолдолд тухайн хугацааг идэвхтэй ашигласан хугацаанд тооцохгүй.
 - 5.2.3 Хэрэглэгч лизингийн хугацаа дуусахаас өмнө төхөөрөмжөө гэмтээх зэрэг ашиглах боломжгүй болсон тохиолдолд үлдэгдэл лизингийн төлбөрийг төлөх үүрэгтэй. Дахин шинэ төхөөрөмжийг худалдаж авах боломжтой.
 - 5.2.4 Урамшуулалтай нөхцөлөөр төхөөрөмж авсан хэрэглэгч гэрээний хугацаанаас өмнө гэрээг цуцлах тохиолдолд үйлчилгээг ашигласан хугацаанаас хамааран тоног төхөөрөмжийн үндсэн үнээс Үйлчилгээ үзүүлэгч талд дараах байдлаар тооцож төлнө.

Хэрэглэгчийн төлөх үнийн дүн	Ашигласан хугацаа					
	1-6 сар	7-12 сар	13-18 сар	19-24 сар	25-36 сар	36-аас дээш сар
	100%	80%	60%	40%	20%	0%

- 5.2.5 Төхөөрөмж лизингийн нөхцөлөөр авсан хэрэглэгч лизингийн хугацаанд түр салгалт хийлгэсэн тохиолдолд төхөөрөмжийн лизингийн төлбөрийг идэвхгүй саруудад нэхэмжлэхгүй. Төхөөрөмжийн лизингийн хугацаа идэвхгүй сарын хугацаагаар сунгагдаж тооцно.
- 5.3 Тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа
 - 5.3.1 Төхөөрөмжийн баталгаат хугацаа 6 сар байна. Баталгаат хугацаанд тоног



төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд үнэгүй сольж өгнө. Төхөөрөмжийн дагалдах хэрэгсэлд баталгаат хугацаа хамаарахгүй.

- 5.3.2 Баталгаат хугацаа хэтэрч тоног төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд хэрэглэгч Үйлчилгээ үзүүлэгчийн тухайн үеийн тогтоосон үнээр төхөөрөмж худалдаж авна.
- 5.3.3 Баталгаат хугацааг дараах тохиолдолд тооцохгүй. Үүнд:
 - 5.3.3.1 Тоног төхөөрөмжийг зориулалтын бусаар ашигласан.
 - 5.3.3.2 Бусад газраар засвар хийлгэсэн, программ хангамжийг өөрчилж, устгаж, зассаны улмаас төхөөрөмж эвдэрсэн.
 - 5.3.3.3 Гадна болон дотор эд ангийн механик гэмтэл, ус, шингэн, шавж орж эвдэрсэн.
 - 5.3.3.4 Хэрэглэгчийн буруугаас эвдэрч, үрэгдсэн.
- 5.4 **Тоног төхөөрөмжийн буцаалт**
- 5.4.1 Төлбөрийн үлдэгдэлгүй, гэрээ цуцалсан хэрэглэгчийн төхөөрөмж түүний дагалдах хэрэгсэл хэвийн ажиллагаатай эвдрэл гэмтэлгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч тухайн үеийн урамшууллын хөтөлбөрт тогтоосон үнэ, заагдсан нэр төрөлд орсон төхөөрөмжийг буцаан авч болно.

ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО

6.1 Ярианы минутын алхам тооцоолол

- 6.1.1 Бацад дагалдах Cally үйлчилгээний Монгол улс доторх яриаг 1 (нэг) минутын алхамаар тооцох бөгөөд 1 (нэг) минут хүрээгүй яриаг 1 (нэг) бүхэл минутаар тооцно. Cally үйлчилгээний ОУ-ын ярианы гарц тухайн улсаас хамаарч 1 (нэг) минутын тариф харилцан адилгүй байна. Бацад дагалдах ярианы минут дууссан тохиолдолд бусад бүх сүлжээний ярианы тарифыг 1 минутын 30₮-өөр тооцно. Түсгай дугаар болон ОУ-ын дуудлага хийх бол тарифыг минутад шилжүүлж тооцно.
- 6.2 **Төлбөрийн нэхэмжлэх**
- 6.2.1 Төлбөрийн нэхэмжлэх нь тухайн сарын суурь хураамж, Үндсэн багцын суурь хураамж, төхөөрөмжийн лизингийн төлбөр, нэмэлт үйлчилгээний төлбөр, өмнөх сарын төлбөрийн үлдэгдэл болон бусад нэмэлт төлбөр, НӨАТ зэргээс бүрдэнэ.
- 6.2.2 Үндсэн багцын суурь хураамж нь Гуравласан үйлчилгээний сарын суурь хураамжийн хамт үйлчилгээний төлбөр дээр нэхэмжлэгдэх бөгөөд Үндсэн багцыг хасуулах болон цуцлах боломжгүй.
- 6.2.3 Хэрэглэгч төлбөрийн нэхэмжлэхийн дагуу төлбөрөө сар бүрийн 06-21-ний өдрийн дотор төлнө.
- 6.2.4 Хэрэглэгч төлбөрийн нэхэмжлэхийг сар бүрийн 6-наас хойших өдрүүдэд мессеж, Скайтел аппликейшн, IPTV цахим салбараар дамжуулан хүлээн авна.
- 6.2.5 Үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчийн өргөдлийн маягт дахь хаяг, гар утасны дугаарт төлбөрийн нэхэмжлэх болон өөрчлөлт орсон үйлчилгээний талаарх мэдээллийг мэдэгдсэн нь хэрэглэгчийг төлбөр төлөхөөс чөлөөлөх, мэдээлэл хүлээн аваагчид тооцох үндэслэл болохгүй.

6.3 Хэрэглээний мэдээлэл

- 6.3.1 Хэрэглэгч сүүлийн 6 сарын хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг авах боломжтой.
- 6.3.2 Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт А4-ийн 2 хуудаснаас хэтэрсэн нөхцөлд 2000₮ төлнө.
- 6.3.3 Cally үйлчилгээний хэрэглэгч өөрийн ярианы дэлгэрэнгүй жагсаалтыг www.cally.mn веб сайтаар өөрийн SIP кодыг ашиглан сүүлийн 6 сарын хугацаагаар харах боломжтой.
- 6.3.4 Хэрэглэгч Skytel.mn веб сайт, Скайтел аппликейшн болон ТВ-Цахим салбар ашиглан төлбөрийн мэдээлэл авах, бүртгэлтэй гар утасны дугаар, и-мэйл хаягийг шинэчлэх боломжтой.

6.4 Үйлчилгээний төлбөр төлөх боломж

- 6.4.1 Хэрэглэгч хэрэглээний төлбөрийг сар бүрийн 21-ний өдрийн дотор доорх сувгуудаас сонгон төлөх боломжтой. Үүнд:
 - 6.4.1.1 Үйлчилгээний бүх салбар,
 - 6.4.1.2 ТВ-цахим салбар,
 - 6.4.1.3 Скайтел веб сайт, аппликейшн, киоск машин,
 - 6.4.1.4 Бүх банкны салбар (QPAY),

6.4.1.5 Интернет болон Мобайл банк,

Банк	Төгрөгийн данс	Банк	Төгрөгийн данс
Худалдаа хөгжлийн банк	499 205 065	Төрийн банк	100 200 013 183
Хаан банк	500 343 9787	Хас банк	500 073 3393
Голомт банк	110 204 7493		

ДОЛОО. ҮЙЛЧИЛГЭЭГ ХЯЗГААРЛАХ

- 7.1 Хэрэглээний төлбөрийг 21-ний дотор төлөөгүй бол 22-нд доорх үйлчилгээний хязгаарлалтыг хийнэ. Үүнд:
 - 7.1.1 Телевизийн сувгийн тоог 5 хүртэл цөөлөх;
 - 7.1.2 Интернетийн хурдыг 0 kbps болгох;
 - 7.1.3 Cally үйлчилгээний гарах ярианы эрх хаалттай, орох ярианы эрх нээлттэй байх ба хэрэглээний хязгаарлалтад хүрсэн тохиолдолд 5.2.3-т заасан хугацаанаас үл хамааран гарах ярианы эрх хаагдана.
- 7.2 Төрийн эрх бүхий байгууллага албан тушаалтнуудаас гаргасан нийтээр дагаж мөрдөх тушаал (шийдвэр, захирамж, хэм хэмжээ тогтоосон акт)-ын дагуу хэрэглэгчийн үйлчилгээг хязгаарлаж, зогсоож болно.

НАЙМ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 8.1 Талууд дараах үндэслэлээр энэхүү гэрээг цуцалж болно. Үүнд:
 - 8.1.1 Гэрээнд заасан аль нэг Тал нь үүргээ биелүүлээгүй бол;
 - 8.1.2 Хэрэглэгчийн эрх зүйн чадвар дуусгавар болсон;
 - 8.1.3 Хуульд заасан бусад үндэслэлээр;
- 8.2 Талууд 8.1-д зааснаас бусад тохиолдолд гэрээг дангаар цуцлахыг хориглоно.
- 8.3 Хэрэглэгч гэрээг цуцлах тухай саналыг үйлчилгээ үзүүлэгчид ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэж үйлчилгээг хаалгана.
- 8.4 Гэрээ цуцалсан сарын төлбөр биллинг циклээр буюу бүтэн тооцогдоно.
- 8.5 Хэрэглэгч үйлчилгээний гэрээний хугацаа 36 сараас өмнө гэрээг цуцлах тохиолдолд үйлчилгээний төвд өөрийн биеэр цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг үндэслэн дараах төлбөрүүдийг төлж барагдуулсан тохиолдолд үйлчилгээг зогсооно. Үүнд:
 - 8.5.1 Үйлчилгээний төлбөрийн үлдэгдэл;
 - 8.5.2 Урамшуулаар авсан тоног төхөөрөмжийн ашигласан хугацаанаас хамаарсан төлбөрийн үлдэгдэл;
 - 8.5.3 Төхөөрөмжийн лизингийн төлбөрийн үлдэгдэл;
- 8.6 Х багцруу шилжин гэрээ байгуулсан хэрэглэгч 36 сарын турш үйлчилгээг тасралтгүй ашиглах үүргээ биелүүлээгүй, гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах тохиолдолд ашиглаагүй сар бүрийн 5000₮-н нөхөн төлбөр төлнө.
- 8.7 Хэрэглэгч гэрээ цуцлах хүсэлтээ албан ёсоор мэдэгдээгүй болон үйлчилгээг түр салгалт хийлгээгүй тохиолдолд тухайн үйлчилгээг 1.2.5-т заасан хугацаанаас хойш 181 дэх хоногт Үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар гэрээг дангаар цуцлах ба Хэрэглэгч нь үйлчилгээ хязгаарлагдах хүртэлх үйлчилгээний төлбөр, тоног төхөөрөмжийн нийт үнэ, Үйлчилгээ үзүүлэгчийн хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхэд гаргасан холбогдох бүх зардал болон учирсан бодит хохирлыг бүрэн хариуцан Үйлчилгээ үзүүлэгчид төлж барагдуулна.

ЕС. БУСАД

- 9.1 Энэхүү Скаймедиа үйлчилгээний нөхцөлд шууд заагаагүй, тусгагдаагүй бусад үйлчилгээний нөхцөлийг тухайн үед Скаймедиа Корпораци ХХК-ийн Хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөлөөр зохицуулагдах ба Скаймедиа үйлчилгээний нөхцөлд Скаймедиа Корпораци ХХК дангаараа өөрчлөлт оруулах эрхтэй.

БАГЦЫН ТӨРӨЛ		X20	X60	X100	G150	G300	G600
Сувгийн тоо**		110+	130+	130+	110+	130+	130+
Үндсэн хурд		20 mbps	60 mbps	100 mbps	150 mbps	300 mbps	600 mbps
Cally ярианы эрх		Скайтел болон Cally сүлжээнд үнэгүй, Бусад бүх сүлжээнд 15,000₮/500минут эрх					
SkyGo		GO Basic					
Контентын эрх	Контент үзэх эрх***	40 контент		100 контент			
	Хүүхдийн кино	Багцад дагалдана					
	Кино галерей	Багцад дагалдана					
Нэмэлт үйлчилгээ	Бичлэг хийх	Багцад дагалдана					
	Нөхөж үзэх, ухраах, зогсоох, дахин эхлүүлэх	Багцад дагалдана					
Smart highlights		Багцад дагалдана					
Нэмэлт сувгийн багц	HBO сувгийн багц	Багцад дагалдана					
	Гэр бүлийн сувгийн багц	Багцад дагалдана					
Өргөн нэвтрүүлгийн үндсэн багц		3500₮				2500₮	

**Сувгийн тоо болон нэмэлт сувгийн багц өөрчлөгдөж болно.
 ***Контент үзэх эрх гэдэгт "ХИТ" тэмдэглэгээтэй контент хамаарахгүй.
 Өргөн нэвтрүүлгийн үндсэн багцын төлбөр суурь хураамжид орохгүй.